



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйчийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний түр ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Гүйцэтгэх үүрэг:

- Гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн материалыг цахим болон үндсэн материалаар хүлээн авч хянан, шийдвэрийг тухай бүр үйлчлүүлэгчид хүргүүлэх
- Гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулахад хамтран ажиллах
- Гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтний Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн чиглэлээр хяналт-үнэлгээ, судалгаа хийж тайлан мэдээ гаргах, урьж ажиллуулах гэж буй байгууллагыг мэдээлэл, арга зүйгээр хангах, эрхлэх ажлын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газартай хамтарч ажиллах
- Эм зүйчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгоход шаардагдах багц цагийг баталгаажуулах,
- Багц цаг биелүүлэн зөвшөөрөл сунгуулах эм зүйчийн материалыг цахим болон үндсэн материалаар хүлээн авч хянан, шийдвэрийг тухай бүр үйлчлүүлэгчид хүргүүлэх
- Эм зүйчийн багц цагийн бүрдүүлэлтэд хяналт-үнэлгээ, судалгаа хийж тайлан мэдээ гаргах, мэдээний сан үүсгэх, баяжуулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

Тавигдах шаардлага:

- Эм зүй, анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд судлалын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
- Шударга, ёс зүйтэй, хариуцлагатай, зарчимч байх
- Эерэг харилцаа, хандлагатай байх

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет
- Их дээд сургууль төгссөн мэргэжлийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулах)
- Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 3x4 цээж зураг - 2%

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б)-ийн 1 дүгээр байр, 2 давхар, 203 тоот өрөөнд 2022 оны 11 сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авна.
Утас: 70128805

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН АЛБА

2022.10.20